

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн
сайдын 2018 оны . . . дугаар сарын . . . ны
өдрийн . . . дугаар тушаалын хавсралт

МАЛ ЭМНЭЛГИЙН СҮЛЖЭЭ ЛАБОРАТОРИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь мал, амьтны өвчин эмгэгийг оношлох малын эрүүл мэндийн байдлыг үнэлэх, мал амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, сорилт баталгаажуулалт хийх эрх бүхий улс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, багийн төрийн болон хувийн өмчит лаборатори, лабораториор үйлчлүүлэгч иргэн, хуулийн этгээд, мал эмнэлгийн хэрэгжүүлэгч байгууллага болон мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нарын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Журмыг үндэсний, аймаг, нийслэл болон аж ахуйн нэгж, байгууллагын мал эмнэлгийн лабораторийн үйл ажиллагаа эрхлэгч төрийн болон хувийн өмчит бүх шатны малын эмч, иргэн, хуулийн этгээд, түүгээр үйлчлүүлэгч иргэн, хуулийн этгээд, мал эмнэлгийн хэрэгжүүлэгч байгууллагын ажилтан, мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нар дагаж мөрдөнө.

Хоёр. Лабораторийн үйл ажиллагааны төрөл, хамрах хүрээ

2.1. Мал эмнэлгийн лабораторийг /цаашид лаборатори гэх/ зориулалтаар нь мал, амьтны өвчин эмгэгийг оношлох оношлогооны, эм, биобэлдмэл, эмийн түүхий эдийн чанар аюулгүй байдалд сорилт, шинжилгээ, баталгаажуулалт хийх чиглэлээр үйл ажиллагаа явуулна.

2.2. Лабораторийг шинжилгээний төрлөөр нь мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, ариун цэврийн магадлан шинжилгээ, сорилт баталгаажуулалт хийх мал эмнэлэг, ариун цэврийн зохион байгуулалт үйл ажиллагааны хамрах хүрээгээр нь үндэсний, аймаг нийслэлийн, орон нутгийн, аж ахуйн нэгж, байгууллагын гэж ангилна.

2.3. Лаборатори нь мал эмнэлгийн оношлогоо, шинжилгээ, ариун цэврийн хосолсон, эсвэл аль нэг чиглэлээр нь дагнасан үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрнө.

2.4. Лаборатори нь өмчийн аль ч хэлбэрийн хуулийн этгээд байж болох бөгөөд аймаг, нийслэлийн лаборатори нь мал эмнэлгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын /үндэсний лавлагаа лаборатори/ нэгдсэн удирдлага, хяналтанд харьяалагдана.

2.5. Лаборатори нь өмчийн аль ч хэлбэрийн хуулийн этгээд байж болох бөгөөд тодорхой шинжилгээний төрлөөр үндэсний хэмжээний лавлагаа лабораторийн эрхтэй байж болно.

2.6. Үндэсний хэмжээний лаборатори нь мал эмнэлгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд мал, амьтны гоц халдварт өвчний эцсийн оношийг тогтоох, урьдчилсан оношийг баталгаажуулах, экспорт, импортын зориулалт бүхий эм, биобэлдмэл, эмийн түүхий эдэд шинжилгээ сорилт, мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, хүнсий бүтээгдэхүүнд мал эмнэлэг ариун цэврийн магадлан шинжилгээ,

баталгаажуулалт хийх, нэгдсэн арга зүйн удирдлагаар хангах, бүх шатны сүлжээ мал эмнэлгийн лабораторийн хийсэн шинжилгээнд хяналтын, экспорт, импортын зориулалтаар бэлтгэгдсэн бүтээгдэхүүнд баталгаажилт, хяналт эрсдлийн үнэлгээ хийнэ.

2.7 Улсын хэмжээний лабораторит гэдэгт Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори, Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори хамаарах бөгөөд бусад сүлжээ лабораториудыг удирдлага, арга зүйн зөвлөмжөөр ханган ажиллана.

2.8 Орон нутгийн төрийн болон хувийн өмчит лаборатори нь аймаг, нийслэлийн мал эмнэлгийн албанд харъяалагдан тухайн харъяалах нутаг дэвсгэрт малын халдваргүй болон халдварт, гоц халдварт, паразиттах өвчний урьдчилсан болон эцсийн онош тавих, үндэсний мал эмнэлгийн лавлагаа лабораторид дээж явуулж онош, шинжилгээг магадлан баталгаажуулах, аж ахуйн нэгж, байгууллагын лабораторийн шинжилгээнд хяналтын, тухайн орон нутгийн хэмжээнд импорт, экспортын зориулалтаар бэлтгэгдсэн мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд сорилт баталгаажилт, хяналт, эрсдлийн үнэлгээ, хийх эрхтэй байж болно.

2.9 Хувийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын лаборатори нь хувийн мал эмнэлгийн нэгж, хүнсний зах, бөөний худалдааны төв, түүхий эдийн болон сүү боловсруулах, мах бэлтгэх (мал нядлах) үйлдвэрийн, тусгай газрын, жижиг амьтны эмнэлэг, гахай, тахианы эрчимжсэн аж ахуйн дэргэдэх гэсэн төрөлтэй байж болно.

2.10 Лаборатори нь мал, амьтны халдваргүй, халдварт, паразиттах өвчнийг оношлох, тандах, батлах, эм, биобэлдмэл, эмийн түүхий эдэд шинжилгээ сорилт, баталгаажуулалт болон мал эмнэлэг ариун цэврийн магадлан шинжилгээг Монгол улсын үндэсний стандарт, Олон улсын мал амьтны эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж, арга, аргачлал, зааврын дагуу хийнэ.

2.11 Эм бэлдмэлийн сорилт, баталгаажуулалтыг малын эмийн үйлдвэрлэгчийн фармакопей, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа үндэсний стандарт, олон улсын фармакопей болон бусад норматив техникийн баримт бичгийн дагуу гүйцэтгэнэ.

2.12 Төрийн болон хувийн өмчит аж ахуйн лаборатори нь мал, амьтны гаралтай мах, махан бүтээгдэхүүн, түүхий эд, малын тэжээл болон бусад амьтны гаралтай бүтээгдэхүүнд мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ /нян, хор судлал, химийн задлан шинжилгээ/ хийж ариун цэвэр, аюулгүйн үзүүлэлтээр шинжилгээ хийж баталгаажуулалт гаргаж болно.

2.13 Төрийн болон хувийн өмчит аж ахуйн нэгжийн лаборатори нь зөвхөн өөрийн итгэмжлэлийн хүрээнд мах, махан, сүү, сүүн бүтээгдэхүүнд анхан шатны мэдрэхүй, чанар, нянгийн бохирдолт илрүүлэх мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ хийж баталгаажилт гаргаж болно.

2.14 Төрийн болон хувийн өмчит аж ахуйн нэгжийн лаборатори нь тухайн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн харъяалах нутаг, дэвсгэрт мал, амьтны гаралтай бүтээгдэхүүнд мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ хийж, гарал үүслийн гэрчилгээг олгоно.

2.15 Төрийн болон хувийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын лаборатори нь шаардлагатай тохиолдолд харъяалах нутаг дэвсгэрт мал, амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжийн түүхий эд,

бүтээгдэхүүнд зөвхөн итгэмжлэлийн хүрээнд авсан лабораторийн шинжилгээ хийж, баталгаажуулалт гаргаж болно.

Гурав. Лабораторид тавих ерөнхий шаардлага

3.1. Мал эмнэлгийн сүлжээ лаборатори нь үйл ажиллагааны чиглэл, бүтэц, зохион байгуулалт, эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлсон дүрэмтэй, чанарын хяналтын тогтолцоог нэвтрүүлэн хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлсэн байна.

3.2. Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн үйл ажиллагаа нь үйлдвэрлэгч, борлуулагч, санхүүжүүлэгч байгууллагаас удирдлага, зохион байгуулалтын хувьд хараат бус, биеэ даасан байдлаар ил тод явагдана.

3.3. Лабораторийн байр нь агааржуулах систем, гэрэлтүүлэг, битүүмжлэл, аюулгүй ажиллагааны талаарх ISO-MNS-17025 стандартын шаардлагыг хангасан, өрөө тасалгаа нь халдвар алдахаас хамгаалагдсан, зөвхөн зориулалтын байна.

3.4. Лаборатори нь халдвартай материал, бусад дээжийг устгах зориулалт бүхий устгалын байгууламж болон тоног төхөөрөмжтэй байна.

3.5. Лаборатори нь мал эмнэлгийн лабораторийн цахим сүлжээнд заавал бүртгэгдэж холбогдсон, шинжилгээ хийсэн тухай анхдагч журнал, дээж авсан, шинжилсэн, устгасан тухай бүртгэл, шинжилгээний хариу олгосон тухай мэдээллийг цахим бүртгэлд оруулж, өөрийн журналд зааврын дагуу тогтмол хөтөлдөг цахим болон бичиг хэргийн архивтай байна.

3.6. Лаборатори нь шинжилгээ хийхэд шаардагдах багаж аппарат, эм урвалж, шил сав, хөргөх, хөлдөөх болон тоног төхөөрөмж, туслах материалаар бүрэн хангагдсан байна.

Дөрөв. Лабораторийн шинжилгээ хийх үйл ажиллагаа

4.1. Лабораторийн үйл ажиллагаа нь дээжийг батлагдсан стандарт, зааврын дагуу шинжлэх, шинжилгээний дүнг энэхүү журам болон бусад эрх зүйн актуудын дагуу дээд шатны лабораториор магадлан хяналт, баталгаажуулах зарчмаар явагдана.

4.2. Төрийн болон хувийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын лаборатори нь магадлан шинжилгээнийхээ 15-аас доошгүй хувийг харьяалагдах нутаг дэвсгэр болон дээд шатны лабораториор шинжлүүлж баталгаажуулсан байна.

4.3. Орон нутгийн лаборатори нь мал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хийсэн шинжилгээний 10-аас доошгүй хувийг, импортын бүтээгдэхүүнд хийсэн шинжилгээний 20-иос доошгүй хувийг, анхан шатны лабораторийн шинжилгээнд хийсэн хяналтын дээжний 5 хүртэл хувийг үндэсний лавлагаа лабораторид шинжлүүлж шинжилгээний дүнг албан ёсоор баталгаажуулсан байна.

4.4. Аж ахуйн нэгж, байгууллагын лаборатори нь мал, амьтны өвчний анхан шатны оношийг шаардлагатай гэж үзвэл харьяалах нутаг дэвсгэрийн дээд шатны лабораториор баталгаажуулна.

4.5. Төрийн болон хувийн өмчит аж, ахуйн нэгж, аймаг нийслэлийн лаборатори нь өөрийн түвшинд эцсийн оношийг тогтоох боломжгүй мал, амьтны өвчний оношийг үндэсний лаборатори болон бусад итгэмжлэлтэй лабораторид шинжлүүлж баталгаажуулалт гаргуулна.

4.6. Лаборатори нь шинжилгээнд дээжийг 2 хувь авч нэг хувийг шинжилгээний хариу гарснаас хойш 60-аас доошгүй хоног хадгална. Дээд шатны лаборатори архив дээжийг шинжилж уг лабораторийн шинжилгээний дүнтэй харьцуулан дүгнэлт гаргаж итгэмжлэлийн хүрээнд үнэлгээ өгнө.

4.7. Бүх шатны лаборатори нь магадлан шинжилгээ, анализын дүнг үндэслэн хариу өгөхдөө шинжилсэн үзүүлэлтүүд, хэрэглэх хугацаа, зориулалт, авах арга хэмжээний заалтыг тодорхой зааж өгнө.

4.8. Лаборатори нь өөрийн үйл ажиллагааны талаарх мэдээ, тайланг харьяалах дээд шатны лабораторит сар, улирал бүрээр цахимаар болон албан бичгээр хүргүүлнэ. Аймаг, нийслэлийн болон улсын хэмжээний лаборатори нь энэхүү мэдээ, тайланг нэгтгэн сар, улирал бүрийн 25-ны дотор цахим болон албан бичгээр Мал эмнэлгийн газарт ирүүлнэ.

4.9. Мал эмнэлгийн сүлжээний харьяалагдах лаборатори нь ур чадварыг үнэлэх чиглэлээр сорилт явуулахаар итгэмжлэгдсэн дээд шатны болон олон улсын ижил төстэй байгууллагаар сорилт гүйцэтгэх ур чадвараа жилд нэг удаа тогтоолгож байна.

Тав. Лабораторийн үйл ажиллагаа эрхлэх

5.1. Улсын хэмжээнд үйл ажиллагаа эрхлэх үндэсний лавлагаа лабораторийн тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох шийдвэрийг мал эмнэлгийн төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

5.2 Хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах бол мал эмнэлгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон тухайн шатны мал эмнэлгийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн мал эмнэлгийн алба, сум, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах бол аймаг, нийслэлийн мал эмнэлгийн алба болон тухайн шатны мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн иргэн, хуулийн этгээдэд сум, дүүргийн мал эмнэлгийн байгууллагаас холбогдох хууль тогтоомжийн дагуу тус тус олгоно.

5.2. Мал эмнэлгийн ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгосон, түтгэлзүүлсэн, цуцалсан тухай мэдээлэл, судалгааг тухайн шатны мал эмнэлгийн байгууллагууд нэгтгэн дээд шатны байгууллагуудад улирал тутамд хүргүүлнэ.

5.3. Лабораторийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь төв, орон нутгийн мал эмнэлгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн албатай гэрээ байгуулан ажиллана.

5.4. Экспортын зориулалтаар бэлтгэгдсэн мал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд лабораторийн шинжилгээ, баталгаажуулалтыг шинжилгээг үндэсний болон аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лаборатори хийж гүйцэтгэнэ.

5.5. Лабораторид дээд боловсролтой, итгэмжлэгдсэн, малын их эмч, мал эмнэлэг ариун цэврийн магадлан шинжээч мэргэжилтэй, магадлан шинжилгээ, оношлогооны чиглэлээр мэргэшсэн боловсон хүчин ажиллана.

5.6. Лаборатори үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш 6 сарын дотор холбогдох хууль, тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагаас итгэмжлэл авсан байна.

Зургаа. Лабораторийн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдийн эрх, үүрэг

6.1. Эрх бүхий лабораторийн шинжлэгч эмч, мал эмнэлгийн магадлан шинжлэгч эмч нь лабораторийг төлөөлж ямар ч тохиолдолд сэжигтэй гэж үзсэн мал, амьтан, түүхий эд, бүтээгдэхүүнээс дээж авч шинжлэх эрхтэй байна.

6.2. Лаборатори нь иргэн, хуулийн этгээдээс малын өвчлөл, хөдөлгөөн, түүхий эд бэлтгэл, тээвэрлэлт, хадгалалтын талаар шаардлагатай мэдээлэл авах эрхтэй.

6.3. Лаборатори нь шинжилгээ хийсэн тухай баримтыг бүрэн бүтэн хадгалж, шаардлагатай тохиолдолд нууцлалыг чандлан хадгална.

6.5. Лаборатори нь дээд шатны лабораторид дээж хүргүүлэхдээ дагалдах хуудсыг хамт илгээх ба урьдчилсан санал, дүгнэлтийг заавал хавсаргана.

6.6. Лабораторийн шинжилгээний дүнгийн хариу бичигт шинжлэгч эмч гарын үсэг зурах ба шинжилгээний дүнд лабораторийн захирал, эрхлэгч гарын үсэг зурж, тамгалж баталгаажуулна.

6.7. Лаборатори нь шинжилгээнд мөрддөг стандарт, техникийн ерөнхий шаардлагын зааврын иж бүрдэл бүхий сантай байх ба байнга баяжуулж ажиллана.

6.8. Бүх шатны лаборатори нь /үндэсний лабораториос бусад/ дээд шатны лабораторид тогтоосон хугацаанд энэхүү журмын 4.2, 4.3 заалтанд заасан дээжийг шинжлүүлэх үүрэгтэй.

6.9. Лабораторийн үйл ажиллагаа эрхлэгч иргэн, хуулийн этгээд нь хийсэн шинжилгээ, гарсан үр дүнг бүрэн хариуцна.

6.10. Лаборатори нь шинжилгээгээр аюулгүйн үзүүлэлтэд тохироогүй эсвэл, үзүүлэлт нь бүрэн гараагүй шинжлэгдэхүүнийг үндэсний болон орон нутгийн лабораториор заавал шинжлүүлсний үндсэн дээр нийгэд мэдээлнэ.

6.11. Лаборатори нь нийтийн зориулалттай хүнсний зүйл бэлтгэх, худалдаалах, хадгалахыг хориглоно.

Долоо. Лабораториор үйлчлүүлэгч иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг

7.1. Лабораторийн дүн болон үйл ажиллагаатай нь холбоотой асуудлаар дээд шатны эсвэл хөндлөнгийн хяналтын лаборатори болон мал эмнэлгийн хяналтын байгууллагад хандаж гомдлоо барагдуулах эрхтэй.

7.2. Мал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээлийг аймаг, нийслэл, сумын нутаг дэвсгэрээс нөгөөд шилжүүлэх, нийтийн хэрэгцээнд нийлүүлэх, тээвэрлэх, хүлээн авах, улсын хилээр нэвтрүүлэхэд мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ заавал хийлгэнэ.

7.3. Иргэн, хуулийн этгээд нь лабораторит хандаж дээж шинжлүүлэх эрхтэй.

7.4. Шинжилгээ хийлгэхтэй холбогдон гарсан зардлыг шинжлүүлэгч этгээд бүрэн хариуцна.

7.5. Малын эмч, мал эмнэлгийн магадлан шинжээч мэргэжилтэнээ сургалтанд хамруулж, мэргэшүүлсэн байна.

7.6. Лабораторийн шаардсанаар ямарч дээжийг иргэн, хуулийн этгээд нь саадгүй авах нөхцөл бололцоогоор хангана.

7.7. Иргэн, хуулийн этгээд нь малын өвчлөл, хөдөлгөөн, түүхий эд бэлтгэсэн тухай үнэн зөв, бодит мэдээлэл өгөх үүрэгтэй.

7.8. Лабораторийн дүнг олшруулах, хувилах, өөрчлөх, засахыг хориглоно.

Найм. Хяналт

8.1. Энэхүү журмын хэрэгжилтэнд бүх шатны мал эмнэлгийн хяналтын байгууллагын мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нар хяналт тавина.

8.2. Мал эмнэлгийн хяналтын бүх шатны байгууллага нь мал эмнэлгийн болон төрийн захиргааны байгууллагыг журмын хэрэгжилт, мал эмнэлгийн лабораторийн үйл ажиллагаатай холбогдсон мэдээ, мэдээллээр хангана.

Ес. Хариуцлага

9.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хуулийн дагуу мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч захиргааны шийтгэл ногдуулна.

9.2. Зөрчилтэй үйлдэл нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр бол мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч холбогдох баримтыг бүрдүүлэн хуулийн байгууллагад шилжүүлнэ.